



АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Сүхбаатар дүүрэг Цагдаагийн
гудамж 78-р байр, Улаанбаатар



08:00-16:30

Mon-Fri

СУРГАЛТЫН АЛБА

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус алба нь Арьс судлал үндсэн мэргэшил олгох сургалт, Арьсны сувилахуйн, Эмчилгээний гоо заслын сувилахуйн чиглэлээр төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг улсын хэмжээнд зохион байгуулах, Арьсны эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, төвийн хэмжээнд бэлтгэгдэн гарч буй мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулж ажилладаг.

Түүнчлэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Монголын Арьс Өнгөний Эмч Нарын Нийгэмлэг, Арьс Судлаачдын Монголын Нийгэмлэгүүдтэй хамтран төрөл бүрийн сургалт семинар зохион байгуулан ажилладаг ба гадаадын ижил мэргэжлийн нийгэмлэг, холбоонууд, их дээд сургуулиудтай хамтран эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг суралцуулах, гадаадын эмч мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах, сургалт явуулах, эмч, мэргэжилтнүүдээ өндөр хөгжилтэй орнуудад үе шаттай хамруулан ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нийгэм сэтгэл зүйн хэрэгцээнд тулгуурласан үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэх, олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, дэмжих орчин бүрдүүлэхэд чиглэсэн мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхээр зорьж ажилладаг.

Сургалтын алба нь эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэн номын сангийн үйл ажиллагааг эрхэлж байна.

ТӨЛБӨР ТӨЛӨХ ДАНС : 100900020013

/АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ-ТӨРИЙН САНГИЙН ДАНС/



976-70135036



ndcmedfac@gmail.com